



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА С.ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.11.12 № 01/70 ЧАГ-ИАТ/2014/02-ЧА

Зөрчил арилгуулах тухай

“Эрүүл мэндийн даатгалын сан, Иргэний нэрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийн байдал”-д нийцлийн аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

НДҮЗ-ийн 2013 оны 1 дүгээр тогтоолоор “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг хүчингүй болгож үйл ажиллагаа нь зогссон байхад Ховд аймгийн НДХ 500.0, Баянхонгор аймгийн НДХ 1,516.3, Дархан-Уул аймгийн НДХ 680.4, Дорнод аймгийн НДХ 1,516.3, Сүхбаатар аймгийн НДХ 1,516.3, Овөрхангай аймгийн НДХ 1,515.2, Өмнөговь аймгийн НДХ 319.7 нийт 7,564.2 мянган төгрөгийн урамшуулалыг Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн дарга, гишүүдэд олгосон байна.

Энэ нь Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан даатгалын зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, даатгалын зөвлөлийн ажиллах журмыг талуудын саналыг үндэслэн батална. Даатгалын зөвлөлийн дарга, гишүүдэд ажлын оролцоог харгалзан урамшуулал олгож болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах, акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 3.1.1-д “… алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг тус тус үндэслэн албан шаардлага хүргүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн ажиллах журмыг нэн даруй шинэчлэн боловсруулж, цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхад анхаарч, албан шаардлагын биелэлтийг 2014 оны 12 дугаар сарын 25-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг НДҮЗ-ийн дарга С.Эрдэнэ, НДЕГ-ын дарга Ц.Уртнасан нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  
ШИНЖЭЭЧ



Л.ХОНГОРЗУЛ  
Л.НЯМТӨМӨР